# МОНГОЛ УЛСЫН ГАДААД СЕКТОРЫН ТОЙМ

**2019 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛ**

## I. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

Урсгал ба хөрөнгийн данс 2019 оны 1 дүгээр улиралд 373 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 530 сая ам.долларын ашигтай, нийт төлбөрийн тэнцэл 220 сая ам.долларын ашигтай гарлаа. Статистикийн алдаа ба орхигдуулгын дүн 63 сая ам.доллар байна.

Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад урсгал ба хөрөнгийн дансны алдагдал 53 сая ам.доллараар буурч, санхүүгийн дансны ашиг 233 сая ам.доллараар өссөн үзүүлэлттэй байна.

Гадаад валютын улсын нөөц тайлант улирлын эцсийн байдлаар 3,653 сая ам.доллар буюу сүүлийн 3 сарын дунджаар тооцсон импортын 6.5 сарын хэрэгцээг хангах түвшинд байна.

**Дүрсэлэл 1. Төлбөрийн тэнцэл**




### Барааны худалдаа

Төлбөрийн тэнцлийн аргачлалаар тооцсон барааны худалдааны эргэлт өнгөрсөн онтой харьцуулахад 18%-иар өсч 2,964 сая ам.долларт хүрсэн ба худалдааны тэнцэл 404 сая ам.долларын ашигтай гарсан.
Тодруулбал, экспортын хувьд, чулуун нүүрсний экспорт 132 сая ам.доллараар (26%), зэсийн баяжмалын экспорт 41 сая ам.доллараар (9%), түүнчлэн СИФ нөхцөлөөр тооцсон хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 119 сая ам.доллараар (30%), хэрэглээний бүтээгдэхүүний импорт 29 сая ам.доллараар (9%), нефтийн бүтээгдэхүүний импорт 36 сая ам.доллараар (16%) тус тус өссөн. Улмаар барааны тэнцлийн ашиг өнгөрсөн оны мөн үеэс 134 сая ам.доллараар өсчээ.

**Дүрсэлэл 2. Барааны худалдаа**




### Үйлчилгээний худалдаа

2019 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлээр үйлчилгээний худалдааны алдагдал өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 5%-иар буюу 29 сая ам.доллараар өсч сая ам.долларт хүрсэн.

Үүнд бусад үйлчилгээний алдагдал 35 сая ам.доллараар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

**Дүрсэлэл 3. Үйлчилгээний худалдаа**




### Анхдагч орлого

Анхдагч орлогын данс 297 сая ам.долларын алдагдалтай гарч, алдагдлын хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 40%-иар буюу 84 сая ам.доллараар өссөн үзүүлэлтэй байна.

2019 оны 1 дүгээр улиралд гадаад бонд үнэт цаасны хүүгийн төлбөрт 90 сая ам.доллар, ногдол ашигт 38 сая ам.доллар, бусад зээлийн хүүгийн төлбөрт 131 сая ам.доллар болон арилжааны банкууд харьяат бусын эзэмшиж буй харилцах, хадгаламжийн дансны хүүгийн төлбөрт нийт 3 сая ам.долларыг тус тус төлсөн байна.

### Хоёрдогч орлого

Хувийн гүйвуулга болон хандив тусламжийн шугамаар 2019 оны 1 дүгээр улиралд Монгол улс нийт 76 сая ам.доллар буюу өнгөрсөн оны мөн үеэс 4 сая ам.доллараар бага орлогыг хүлээн авчээ. Үүнд:

- Гадаадад ажиллаж, амьдарч буй Монгол иргэдээс хүлээн авсан мөнгөн гүйвуулга өмнөх оны мөн үеэс 10%-иар буурсан бол гадаад руу шилжүүлсэн мөнгөн гүйвуулга 11%-иар өссөн, цэвэр дүнгээр 25 сая ам.долларын орлого авсан.
- Гадаад хандив тусламжийн орлого өмнөх оны мөн үеэс 7 сая ам.доллараар өссөн дүнтэй байна.

**Хүснэгт 1. Хувийн гүйвуулга 2019, I улирал (мян ам.доллар)**

| | | Хүлээн авсан | | | | Шилжүүлсэн | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Мөнгөн дүн | Хувийн жин | | Өсөлт | Мөнгөн дүн | Хувийн жин | | Өсөлт |
| Солонгос | KR | 31,128 | 52% | ▼ | -17% | 5,005 | 15% | ▼ | -26% |
| Америк | US | 4,594 | 8% | ▼ | -60% | 4,222 | 12% | ▲ | 22% |
| Хятад | CN | 240 | 0% | ▼ | -35% | 1,221 | 4% | ▲ | 8% |
| Гонг Конг | HK | 710 | 1% | ▲ | 20% | 481 | 1% | ▲ | 77% |
| Англи | GB | 587 | 1% | ▼ | -75% | 1,976 | 6% | ▲ | 67% |
| ОХУ | RU | 9,177 | 15% | ▲ | 3631% | 2,168 | 6% | ▲ | 47% |
| Сингапур | SG | 963 | 2% | ▲ | 152% | 1,490 | 4% | ▲ | 339% |
| Швейцарь | CH | 1,185 | 2% | ▲ | 5% | 180 | 1% | ▲ | 96% |
| Герман | DE | 1,563 | 3% | ▲ | 61% | 636 | 2% | ▼ | -16% |
| Япон | JP | 806 | 1% | ▼ | -20% | 966 | 3% | ▲ | 37% |
| Бусад | | 8,754 | 15% | ▲ | 29% | 15,883 | 46% | ▲ | 50% |
| НИЙТ | | 59,707 | 100% | | | 34,227 | 100% | | |

# Гадаадын шууд хөрөнгө оруулалт

2019 оны 1 дүгээр улиралд Монгол улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалын дүн 581 сая ам.доллар, хөрөнгө оруулалтын буцаалт болон зээлийн эргэн төлөлттэй холбоотой гарах урсгал 106 сая ам.доллар буюу цэвэр дүнгээр 475 сая ам.долларын орох урсгалтай байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулбал 38 сая ам.доллараар буурсан байна.

Шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг голлох улсаар нь авч үзвэл:

- Сингапур улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 15 сая ам.доллараар өсч 29 сая ам.доллар,
- Люксенбург улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 15 сая ам.доллараар өсч 25 сая ам.долларт хүрсэн бол,
- БНХАУ-аас орж ирсэн хөрөнгө оруулалт 85 сая ам.доллараар буурч 16 сая ам.доллар,
- БНСУ-аас улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 9 сая ам.доллараар буурч 3 сая ам.долларын урсгалтай гарсан байна.

Эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл 2019 оны 1 дүгээр улиралд уул уурхайн салбарт орж ирсэн хөрөнгө оруулалт өнгөрсөн оны гүйцэтгэлээс буурсан үзүүлэлттэй байна.

Салбаруудын хөрөнгө оруулалтын хэмжээг харьцуулбал:

- Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааны салбарт орж ирсэн хөрөнгө оруулалт 21 сая ам.доллараар,
- Бөөний болон жижиглэн худалдааны салбар 14 сая ам.доллараар өсч,
- Үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбар 11 сая ам.доллараар,
- Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагааны салбар 3 сая ам.доллараар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

**Хүснэгт 2. ГШХО, орох урсгал, улсаар (сая ам.доллар)**

| № | Үзүүлэлт | 2019 Дүн | 2019 Хувийн жин | 2019.I/18.I Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|
| 1 | Австрали | 7 | 1% | 4 | ▲ |
| 2 | Америк | 9 | 1% | 9 | ▲ |
| 3 | Англи | 13 | 2% | 12 | ▲ |
| 4 | БНХАУ | 16 | 3% | -85 | ▼ |
| 5 | Герман | 8 | 1% | 7 | ▲ |
| 6 | Нидерланд | 2 | 0% | 2 | ▲ |
| 7 | Хонг-Конг | 10 | 2% | -8 | ▼ |
| 8 | Канад | 395 | 68% | -4 | ▼ |
| 9 | Люксенбург | 25 | 4% | 15 | ▲ |
| 10 | ОХУ | 11 | 2% | 10 | ▲ |
| 11 | Сингапур | 29 | 5% | 15 | ▲ |
| 12 | Солонгос (өмнөд) | 3 | 1% | -9 | ▼ |
| 13 | Турк | 0 | 0% | 0 | ▼ |
| 14 | Франц | 0 | 0% | -5 | ▼ |
| 15 | Япон | 40 | 7% | 11 | ▲ |
| 16 | Бусад | 12 | 2% | -12 | ▼ |
| | **Нийт** | **581** | **100%** | **-38** | ▼ |

**Хүснэгт 3. ГШХО, орох урсгал, салбараар (сая ам.доллар)**

| № | Эдийн засгийн салбар | I улирал 2018 | I улирал 2019 | 2019.I/18.I Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|
| 1 | Барилга | 13 | 11 | -2 | ▼ |
| 2 | Боловсрол | 0 | 2 | 2 | ▲ |
| 3 | Боловсруулах үйлдвэрлэл | 4 | 5 | 1 | ▲ |
| 4 | Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ | 24 | 37 | 14 | ▲ |
| 5 | Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ | 0 | 0 | 0 | ▲ |
| 6 | Мэдээлэл, холбоо | 0 | 2 | 2 | ▲ |
| 7 | Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа | 4 | 1 | -3 | ▼ |
| 8 | Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | 21 | 34 | 13 | ▲ |
| 9 | Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | 0 | 9 | 8 | ▲ |
| 10 | Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа | 2 | 23 | 21 | ▲ |
| 11 | Уул уурхай, олборлолт | 529 | 443 | -86 | ▼ |
| 12 | Үйлчилгээний бусад үйл ажиллагаа | 18 | 6 | -11 | ▼ |
| 13 | Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа | 0 | 3 | 3 | ▲ |
| 14 | Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур | 0 | 1 | 1 | ▲ |
| 15 | Цахилгаан, хий, уур, агааржуулалт | 1 | 1 | 0 | ▼ |
| 16 | Бусад | 1 | 2 | 1 | ▲ |
| | **Нийт** | **618** | **581** | **-38** | ▲ |

# Багцын хөрөнгө оруулалт

Багцын хөрөнгө оруулалтын данс 2019 оны 1 дүгээр улиралд 340 сая ам.долларын ашигтай гарч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 502 сам ам.доллараар өссөн байна.

Тайлант хугацааны голлох ажил гүйлгээг дурдвал:

- МИК 300 сая ам.долларын бонд гаргасан,
- Хуралдай бондын хүүгийн төлбөрт 26 сая ам.доллар,
- Энержи ресурс ХХК-ийн бондын хүүгийн төлбөрт 16 сая ам.долларыг эдийн засгийн харьяат бус тус тус төлжээ.

**Дүрслэл 4. Багцын хөрөнгө оруулалт (сая ам.доллар)**




# Бусад хөрөнгө оруулалт

Энэ дансанд санхүүгийн дээрх дансуудад үл хамаарах бусад хөрөнгө оруулалтууд болох арилжааны, хөнгөлөлттэй, худалдааны зээл бүх төрлийн зээлүүд, бэлэн мөнгө ба харилцах хадгаламжийн дансны эх үүсвэрийг бүртгэдэг.

Тайлант улиралд бусад хөрөнгө оруулалтын данс цэвэр дүнгээр 277 сая ам.долларын орох урсгалтай байсан бөгөөд үүнийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулбал 258 сая ам.доллараар муудсан үзүүлэлт юм. Энэхүү өөрчлөлтөд арилжааны банкуудын харилцах хадгаламжийн данс буурсан нь голлон нөлөөлсөн байна.

**Дүрслэл 5. Бусад хөрөнгө оруулалт**



# II. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦ

Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц 2019 оны 1 дүгээр улиралд цэвэр дүнгээр 34,356 сая ам.долларын үлдэгдэлтэй буюу өр төлбөртэй байна.

Монгол Улсын эдийн засгийн харьяатаас гадагш хийсэн хөрөнгө оруулалтын дүн (актив) 6,528 сая ам.доллар байна. Үүний 56%-ийг гадаад валютын албан нөөц, 31%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 8%-ийг шууд хөрөнгө оруулалт, 4%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Харин Монгол Улсын эдийн засгийн харьяатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн (пассив) 40,884 сая ам.долларт хүрчээ. Үүний 51%-ийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 37%-ийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 13%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус эзэлж байна.

Гадаад хөрөнгө оруулалтын богино позиц өмнөх оны мөн үеэс 5%-иар буюу 1,670 сая ам.доллараар өссөн байна. Үүнийг

- Ерөнхий бүтцээр авч үзвэл, гадаад актив 16%-иар буюу 901 сая ам.доллараар, гадаад пассив 7%-иар буюу 2,571 сая ам.доллараар тус тус өссөн,
- Данс тус бүрээр авч үзвэл, гадаадын шууд хөрөнгө оруулалтын позиц 2,105 сая ам.доллараар, багцын хөрөнгө оруулалтын позиц 466 сая ам.доллараар, албан нөөц 670 сая ам.доллараар тус тус өсч, бусад хөрөнгө оруулалтын позиц 228 сая ам.доллараар буурснаар тайлбарлагдаж байна.
- Тайлант улирлын позицийн өөрчлөлтийг бүтцээр авч үзвэл, төлбөрийн тэнцлийн урсгалаар –311 сая, ханшийн өөрчлөлтөөр –30 сая, бусад өөрчлөлтөөр –377 сая, үнийн өөрчлөлтөөр –2 сая ам.доллараар тус тус өөрчлөгджээ.

**Хүснэгт 4. Позиц (сая ам.доллар)**

| Үзүүлэлт | 3/31/2018 | 3/31/2019 | Өөрчлөлт дүн | Өөрчлөлт хувь |
|---|---|---|---|---|
| **Гадаад хөрөнгө оруулалтын позиц** | **-32,686** | **-34,356** | **1,670** | **5%** |
| **I. Гадаад актив** | **5,627** | **6,528** | **901** | 16% |
| 1. Шууд хөрөнгө оруулалт | 519 | 545 | 26 | 5% |
| 2. Багцын хөрөнгө оруулалт | 270 | 277 | 07 | 3% |
| 3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл | 06 | 03 | -02 | -42% |
| 4. Бусад хөрөнгө оруулалт | 1,849 | 2,050 | 200 | 11% |
| 5. Нөөц актив | 2,983 | 3,653 | 670 | 22% |
| **II. Гадаад пассив** | **38,313** | **40,884** | **2,571** | **7%** |
| 1. Шууд хөрөнгө оруулалт | 18,566 | 20,697 | 2,131 | 11% |
| 2. Багцын хөрөнгө оруулалт | 4,758 | 5,231 | 473 | 10% |
| 3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл | 06 | 00 | -06 | -92% |
| 4. Бусад хөрөнгө оруулалт | 14,983 | 14,956 | -28 | 0% |

**Дүрслэл 6. Гадаад актив, пассив**




## Шууд хөрөнгө оруулалт

Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийн 55%-ийг буюу 11,288 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 45% буюу 9,409 сая ам.долларыг толгой компаниасаа авсан зээл (компани хоорондын өглөг, санхүүжилт) эзэлж байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийг хөрөнгө оруулагч улсаар нь харуулбал:

- Канад улсаас 6,383 сая ам.доллар буюу нийт хөрөнгө оруулалтын 31%,
- БНХАУ-аас 4,893 сая ам.доллар буюу 24%,
- Сингапур улсаас 1,661 сая ам.доллар буюу 8%,
- Люксембург улсаас 1,416 сая ам.доллар буюу нийт хөрөнгө оруулалтын үлдэгдлийн 7%-тай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалтыг манай улсад тус тус оруулсан байна.

**Дүрслэл 7. Шууд ХО-ын үлдэгдэл, 2018 он**




## Багцын хөрөнгө оруулалт

Монгол Улсын багцын хөрөнгө оруулалтын гадаад активын үлдэгдэл 2019 оны 1 дүгээр улиралд 277 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 3%-иар өссөн бол гадаад пассивын үлдэгдэл 5,231 сая ам.долларт хүрч 10%-иар буурсан үзүүлэлттэй байна.

**Актив:** Эдийн засгийн харьяатуудын эзэмшиж буй үнэт цаасыг гаргасан улсаар нь авч үзвэл Хонг-Конг 36%, АНУ 17%, Сингапур 10%, Австрали 8%, Их Британ 7%-ийг тус тус эзэлж байна.

**Пассив:** Эдийн засгийн харьяатуудын гаргасан үнэт цаасыг эзэмшигч улсаар нь ангилбал АНУ 15%, Их Британ 7%, Люксенбург 5%, Сингапур 3%, Хонг Конг 3%, үлдсэн 57% нь хоёрдогч зах зээл дээр арилжаалагдаж байгаа учраас хөрөнгө оруулагчийн харьялах улсыг тодорхойлох боломжгүй байна.

**Дүрслэл 8. Багцын ХО-ын үлдэгдэл, 2018 он**



# III. ГАДААД ӨРИЙН СТАТИСТИК

Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 2019 оны 1 дүгээр улирлын эцсийн байдлаар 29,522 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлээс 1,616 сая ам.доллараар өссөн байна.

**Улсын салбар:** Засгийн газрын гадаад өр 20 сая ам.доллараар өсч 7,262 сая ам.долларт, харин Монголбанкны гадаад өр 64 сая ам.доллараар буурч 2,072 сая ам.долларт хүрчээ.

**Бусад салбар:** Банк, бусад секторын болон хөрөнгө оруулагчийн зээлийг бүхэлд нь хувийн хэвшлийн салбарын гадаад өр гэж ойлгох бөгөөд энэ дүн өнгөрсөн оны мөн үеэс 1,661 сая ам.доллараар өсч 20,187 сая ам.долларт хүрээд байна.

**Хүснэгт 5. Нийт гадаад өрийн үлдэгдэл (сая ам.доллар)**

| Үзүүлэлт | 3/31/2018 | 3/31/2019 | өөрчлөлт | | * % |
|---|---|---|---|---|---|
| | | | *дүн* | *хувь* | |
| **Нийт гадаад өр** | **27,905** | **29,522** | **1,616** | **6%** | **100%** |
| **I. Засгийн газар** | **7,242** | **7,262** | **20** | **0%** | **25%** |
| Бонд, өрийн бичиг | 3,340 | 2,970 | -371 | -11% | |
| Зээл | 3,902 | 4,293 | 391 | 10% | |
| **II. Төв банк** | **2,137** | **2,072** | **-64** | **-3%** | **7%** |
| **III. Банк** | **2,347** | **2,393.4** | **47** | **2%** | **8%** |
| Богино хугацаат | 769 | 780 | 11 | 1% | 3% |
| Урт хугацаат | 1,578 | 1,613 | 35 | 2% | 5% |
| **IV. Бусад сектор** | **7,944** | **8,385** | **440** | **6%** | **28%** |
| Богино хугацаат | 665 | 630 | -35 | -5% | 2% |
| Урт хугацаат | 7,279 | 7,755 | 475 | 7% | 26% |
| **V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл** | **8,235** | **9,409** | **1,174** | **14%** | **32%** |

**: Нийт өсөлтөд оруулсан хувь*

## Банкны салбар

Банкны салбарын гадаад өр төлбөрийн үлдэгдэл 2019 оны 1 дүгээр улирлын эцэст 2,393 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 47 сая ам.доллараар өсчээ.

Гадаад өрийн 41%-ийг урт хугацаат зээл, 27%-ийг бонд өрийн бичиг, 16%-ийг богино хугацаат зээл, үлдсэн 17%-ийг эдийн засгийн харьяат бусын эзэмшиж буй харилцах, хадгаламжийн дансны өглөг тус тус бүрдүүлж байна.

Банкуудын урт болон богино хугацаат арилжааны зээлийн үлдэгдэл харгалзан 973 сая ам.доллар, 378 сая ам.долларт хүрсэн үзүүлэлттэй байна.

**Дүрслэл 9. Банкны салбарын гадаад зээл**




## Банкнаас бусад салбар

Банкнаас бусад салбарын буюу аж ахуйн нэгж, иргэдийн гадаад өр төлбөр 2019 оны 1 дүгээр улирлын эцэст 17,794 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оноос 1,615 сая ам.доллараар өссөн дүнтэй байна.

Салбарын нийт зээлийн 53% буюу 9,409 сая ам.долларын эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчдаасаа авсан зээл буюу компани хоорондын өглөг бөгөөд үүний дийлэнх нь уул уурхайн салбарт ашиглагдсан байна.

Хөрөнгө оруулагчдаас авсан зээлийн эх үүсвэр нь компанийн эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаат санхүүжилт бөгөөд ихэнх тохиолдолд хүүгүй, хатуу мөрдөх эргэн төлөлтийн хуваарь байхгүй, харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдгаараа бусад төрлийн зээлийн санхүүжилтээс ялгаатай байдаг.

Эдийн засгийн харьяат аж ахуйн нэгжүүдийн гадаадаас хүлээн авсан экспортын барааны урьдчилгаа болон төлбөрийг хийгээгүй боловч хүлээн авсан импортын барааны төлбөрийн үлдэгдэл тайлант улирлын эцсийн байдлаар 288 сая ам.доллар болсон байна.

**Дүрслэл 10. Банк бус хувийн хэвшлийн гадаад зээл**




**Мэдээллийн эх сурвалж:**

1. Засгийн газар: Сангийн яам, Өрийн удирдлагын хэлтэс
2. Монголбанк: ТТБГазар, ССГазар
3. Банк: Банкуудын тайлан тэнцэл, төлбөрийн тэнцлийн сарын мэдээ, гадаад зээлийн бүртгэл
4. Бусад салбар: ААН-ийн Төлбөрийн тэнцлийн улирлын мэдээ, банкуудын гадаад гүйлгээний тайлан, гадаад зээлийн бүртгэлийн мэдээллийг тус тус ашиглав.

## ХАВСРАЛТ 1. МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ХУРААНГУЙ ХҮСНЭГТ (сая ам.доллар)

| Үзүүлэлт | I улирал | | | Өөрчлөлт | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2017 | 2018 | 2019 | Дүн | 2018/17 | Дүн | 2019/18 |
| **I. УРСГАЛ ДАНС** | **-148** | **-441** | **-393** | **-293** | **-198%** | **48** | **11%** |
| **Бараа ба үйлчилгээний худалдаа** | **92** | **-308** | **-172** | **-400** | **-436%** | **136** | **44%** |
| **Кредит** | **1,375** | **1,560** | **1,903** | **186** | **13%** | **343** | **22%** |
| **Дебет** | **1,283** | **1,868** | **2,075** | **585** | **46%** | **207** | **11%** |
| **1. Бараа** | **425** | **239** | **404** | **-187** | **-44%** | **165** | **69%** |
| 1.1 Экспорт Ф.О.Б (кредит) | 1,210 | 1,371 | 1,684 | 161 | 13% | 313 | 23% |
| 1.2 Импорт Ф.О.Б (дебит) | 784 | 1,132 | 1,280 | 348 | 44% | 148 | 13% |
| **2. Үйлчилгээ** | **-334** | **-547** | **-576** | **-213** | **-64%** | **-29** | **-5%** |
| Кредит | 165 | 189 | 219 | 24 | 15% | 30 | 16% |
| Дебет | 498 | 736 | 795 | 237 | 48% | 59 | 8% |
| 2.1 Тээвэр | -64 | -109 | -110 | -45 | -71% | -1 | -1% |
| Кредит | 67 | 76 | 86 | 9 | 14% | 10 | 13% |
| Дебит | 131 | 185 | 196 | 55 | 42% | 10 | 6% |
| 2.2 Аялал | -98 | -199 | -192 | -101 | -104% | 7 | 3% |
| Кредит | 37 | 43 | 48 | 6 | 17% | 6 | 13% |
| Дебит | 134 | 241 | 241 | 107 | 80% | -1 | 0% |
| 2.3 Бусад үйлчилгээ | -172 | -239 | -274 | -67 | -39% | -35 | -15% |
| Кредит | 61 | 70 | 85 | 9 | 14% | 15 | 21% |
| Дебит | 234 | 309 | 359 | 75 | 32% | 50 | 16% |
| **3 Анхдагч орлого** | **-280** | **-213** | **-297** | **67** | **24%** | **-84** | **-40%** |
| Кредит | 18 | 81 | 95 | 63 | 350% | 14 | 17% |
| Дебет | 298 | 294 | 392 | -4 | -1% | 99 | 34% |
| 3.1 Ажилчдын цалин | -13 | 45 | 61 | 59 | 436% | 16 | 35% |
| 3.2 Хөрөнгө оруулалтын орлого | -267 | -260 | -362 | 7 | 2% | -101 | -39% |
| 3.3 Бусад | 0 | 2 | 3 | 2 | | 1 | 39% |
| **4 Хоёрдогч орлого** | **40** | **80** | **76** | **40** | **99%** | **-4** | **-4%** |
| Кредит | 58 | 112 | 113 | 54 | 94% | 0 | 0% |
| Дебит | 18 | 32 | 36 | 15 | 81% | 4 | 11% |
| Үүнээс: Хувийн гуйвуулга | 4 | 38 | 41 | 34 | 830% | 3 | 7% |
| **II. ХӨРӨНГИЙН ДАНС** | **18** | **15** | **20** | **-3** | **-18%** | **5** | **32%** |
| **1. Үйлдвэрлэхгүй санхүүгийн бус хөрөнгийн өсөлт/ бууралт** | **0** | **0** | **0** | **0** | | **0** | |
| Кредит | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| Дебет | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| **2. Хөрөнгийн шилжүүлэг** | **18** | **15** | **20** | **-3** | **-18%** | **5** | **32%** |
| Кредит | 19 | 15 | 20 | -4 | -22% | 5 | 33% |
| Дебет | 1 | 0 | 0 | -1 | -79% | 0 | 85% |
| **Урсгал болон Хөрөнгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээллэг -)** | **-130** | **-426** | **-373** | **-296** | **-228%** | **53** | **12%** |
| **III. САНХҮҮГИЙН ДАНС** | **-120** | **-298** | **-530** | **-177** | **-147%** | **-233** | **-78%** |
| **Санхүүгийн дансны тэнцэл (зээлдүүлэг + / зээллэг -)** | **-120** | **-298** | **-530** | **-177** | **-147%** | **-233** | **-78%** |
| **1. Шууд хөрөнгө оруулалт** | **-138** | **-478** | **-466** | **-340** | **-247%** | **12** | **3%** |
| 1.1 Актив | 4 | 24 | 9 | 21 | 586% | -16 | -64% |
| 1.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх | 4 | 20 | 7 | 17 | 476% | -13 | -64% |
| 1.1.2 Өрийн хэрэгсэл | 0 | 4 | 1 | 4 | | -3 | |
| 1.2 Пассив | 141 | 502 | 475 | 361 | 255% | -28 | -6% |
| 1.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх | 81 | 272 | 294 | 192 | 237% | 21 | 8% |
| 1.2.2 Өрийн хэрэгсэл | 61 | 230 | 181 | 169 | 279% | -49 | -21% |
| **2. Багцын хөрөнгө оруулалт** | **54** | **162** | **-340** | **109** | **203%** | **-502** | **-310%** |
| 2.1 Актив | -4 | 14 | -1 | 18 | 479% | -15 | -109% |
| 2.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх | -4 | 14 | 3 | 18 | 459% | -11 | -81% |
| 2.1.2 Өрийн бичиг | 0 | 0 | -4 | 0 | -97% | -4 | |
| 2.2 Пассив | -57 | -148 | 339 | -91 | -159% | 487 | 329% |
| 2.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх | -7 | -8 | 0 | -1 | -14% | 8 | 98% |
| 2.2.2 Өрийн бичиг | -50 | -140 | 339 | -90 | -179% | 479 | 342% |
| **3. Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд** | **17** | **0** | **-1** | **-17** | -103% | **0** | **-33%** |
| 3.1 Актив | 0 | 6 | -1 | 6 | 2703% | -7 | -114% |
| 3.2 Пассив | -17 | 6 | 0 | 23 | 138% | -7 | -102% |
| **4. Бусад хөрөнгө оруулалт** | **-53** | **19** | **277** | **72** | **136%** | **258** | **1353%** |
| 4.1 Актив | -155 | 71 | 263 | 226 | 146% | 192 | 269% |
| 4.1.1 Бусад хөрөнгө | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| 4.1.2 Бэлэн мөнгө ба харилцах | -152 | 157 | 232 | 309 | 203% | 75 | 48% |
| 4.1.3 Зээл | -2 | -6 | 6 | -4 | -148% | 12 | 209% |
| 4.1.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| 4.1.5 Худалдааны зээл ба урьдчилгаа | -1 | -80 | 25 | -79 | -15791% | 104 | 79x |
| 4.1.5.1 Богино хугацаат | -1 | -80 | 25 | -79 | -15791% | 104 | 79x |
| 4.1.5.2 Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| 4.1.5 Бусад авлага | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| 4.2 Пассив | -102 | 52 | -14 | 154 | 151% | -66 | -126% |
| 4.2.1 Бусад хөрөнгө | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| 4.2.2 Бэлэн мөнгө ба харилцах | 17 | 18 | 34 | 1 | 9% | 16 | 89% |
| 4.2.3 Зээл | -106 | 57 | 25 | 163 | 154% | -32 | -56% |
| 4.2.3.1 Төв банк | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| 4.2.3.3 Хадгаламжийн байгууллагууд | -44 | 81 | 39 | 125 | 282% | -42 | -52% |
| 4.2.3.3.1 Богино хугацаат | 19 | 65 | -25 | 46 | 244% | -89 | -138% |
| 4.2.3.3.2 Урт хугацаат | -63 | 16 | 64 | 79 | 125% | 48 | 298% |
| 4.2.3.2 Засгийн газар | 58 | 28 | 48 | -30 | -52% | 20 | 72% |
| 4.2.3.4 Бусад салбар | -120 | -52 | -62 | 68 | 57% | -10 | -19% |
| 4.2.3.4.1 Богино хугацаат | 54 | -22 | -58 | -76 | -140% | -37 | -171% |
| 4.2.3.4.2 Урт хугацаат | -174 | -30 | -3 | 144 | 83% | 27 | 89% |
| 4.2.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| 4.2.5 Худалдааны зээл ба урьдчилгаа | -12 | -23 | -73 | -11 | -86% | -50 | -218% |
| 4.2.5.1 Богино хугацаат | -12 | -23 | -73 | -11 | -86% | -50 | -218% |
| 4.2.5.2 Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| 4.2.6 Бусад авлага | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| 4.2.7 Зээлжих тусгай эрх | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |
| **IV. Алдаа болон орхигдуулга** | **-154** | **86** | **63** | **241** | **2** | **-23** | **0** |
| **V. НӨӨЦ ХӨРӨНГӨ** | **-164** | **-42** | **220** | **121** | **74%** | **262** | **620%** |
| 1. ГВУН | -164 | -12 | 220 | 152 | | 231 | |
| 2. ОУВС-гийн зээл | 0 | 31 | 0 | 31 | | -31 | |
| 3. Тусгай санхүүжилт | 0 | 0 | 0 | 0 | | 0 | |

** [-] утга нь өсөлтийг, [+] утга нь бууралтыг тус тус илэрхийлнэ.*

*Эх сурвалж: Монголбанк*

## ХАВСРАЛТ 2. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН (сая ам.доллар)

| Үзүүлэлт | 12/31/2017 | 03/31/2018 | 06/30/2018 | 09/30/2018 | 12/31/2018 | 03/31/2019 |
|---|---|---|---|---|---|---|
| **Гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц** | -32,031 | -32,686 | -32,768 | -33,292 | -33,637 | -34,356 |
| **Актив** | 5,553 | 5,627 | 5,647 | 5,397 | 6,149 | 6,528 |
| **Шууд хөрөнгө оруулалт** | 495 | 519 | 521 | 525 | 533 | 545 |
| **Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх** | 427 | 447 | 450 | 455 | 466 | 477 |
| Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч | 427 | 447 | 450 | 455 | 466 | 477 |
| Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хамааралтай компани хооронды | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| *үүнээс: Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх* | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| *үүнээс: Мөнгөний захын сангийн хувьцаа/ нэгж эрх* | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Өрийн хэрэгсэл** | 68 | 72 | 71 | 70 | 67 | 68 |
| Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч | 68 | 71 | 70 | 69 | 66 | 68 |
| Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт) | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 |
| Хамааралтай компани хооронды | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Багцын хөрөнгө оруулалт** | 268 | 270 | 275 | 286 | 290 | 277 |
| **Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх** | 254 | 256 | 258 | 269 | 279 | 271 |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад) | 18 | 28 | 29 | 21 | 23 | 22 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 236 | 228 | 229 | 248 | 256 | 249 |
| Бусад санхүүгийн байгууллага | 168 | 172 | 184 | 193 | 210 | 213 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 69 | 56 | 45 | 56 | 46 | 36 |
| Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхээс бусад хөрөнгийн үнэт цаас | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бүртгэлтэй | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бүртгэлгүй | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| үүнээс: Мөнгөний захын сангийн хувьцаа/ нэгж эрх | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Өрийн бичиг** | 14 | 14 | 17 | 17 | 10 | 6 |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад) | 6 | 6 | 6 | 6 | 7 | 7 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 6 | 6 | 6 | 6 | 7 | 7 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 8 | 8 | 10 | 10 | 3 | -1 |
| Богино хугацаат | 1 | 1 | 3 | 3 | 3 | 3 |
| Урт хугацаат | 7 | 7 | 8 | 8 | 0 | -4 |
| Бусад санхүүгийн байгууллага | 0 | 0 | 0 | 0 | 0 | -7 |
| Богино хугацаат | 1 | 1 | 2 | 3 | 3 | 3 |
| Урт хугацаат | 7 | 7 | 1 | 8 | 0 | 0 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 0 | 0 | 0 | 0 | 0 | -4 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | -4 |
| **Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад) ба ажилчдын хувьцааны опцион** | -0 | 6 | 6 | 0 | 0 | 3 |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад) | -0 | 6 | 6 | 0 | 0 | 3 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад санхүүгийн байгууллагууд | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Опцион | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Форвард хэлбэрийн хэлцлүүд | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Ажилчдын хувьцааны опцион | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Бусад хөрөнгө оруулалт** | 1,782 | 1,849 | 1,856 | 1,692 | 1,784 | 2,050 |
| **Бусад хөрөнгө** | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Бэлэн мөнгө ба харилцах** | 1,328 | 1,477 | 1,441 | 1,292 | 1,283 | 1,517 |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад) | 461 | 605 | 643 | 532 | 461 | 806 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 867 | 872 | 798 | 759 | 822 | 711 |
| **Зээл** | 61 | 60 | 60 | 60 | 150 | 156 |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад) | 60 | 60 | 60 | 60 | 150 | 156 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 2 | -0 | -0 | -0 | -0 | 0 |
| **Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем (F60)** | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Худалдааны зээл ба урьдчилгаа** | 392 | 313 | 355 | 340 | 352 | 376 |
| **Бусад дансны авлага/өглөг** | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Нөөц хөрөнгө** | 3,008 | 2,983 | 2,989 | 2,894 | 3,542 | 3,653 |

*Эх сурвалж:* Монголбанк

## Үргэлжлэл.

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| **Шууд хөрөнгө оруулалт** | **18,020** | **18,566** | **19,121** | **19,579** | **20,223** | **20,697** |
| **Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх** | **10,023** | **10,330** | **10,660** | **10,708** | **10,995** | **11,288** |
| Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч | 10,023 | 10,330 | 10,660 | 10,708 | 10,995 | 11,288 |
| Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хамааралтай компани хоорондын | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| *үүнээс: Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх* | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| *үүнээс: Мөнгөний захын сангийн хувьцаа/ нэгж эрх* | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Өрийн хэрэгсэл** | **7,996** | **8,235** | **8,461** | **8,871** | **9,228** | **9,409** |
| Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч | 7,996 | 8,235 | 8,461 | 8,871 | 9,228 | 9,409 |
| Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хамааралтай компани хоорондын | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Багцын хөрөнгө оруулалт** | **4,937** | **4,758** | **4,394** | **4,505** | **4,887** | **5,231** |
| **Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх** | 71 | 71 | 69 | 79 | 75 | 74 |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад) | 11 | 11 | 11 | 21 | 21 | 21 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 60 | 60 | 58 | 58 | 54 | 53 |
| Бусад санхүүгийн байгууллага | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхээс бусад хөрөнгийн үнэт цаас | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бүртгэлтэй | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бүртгэлгүй | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| үүнээс: Мөнгөний захын сангийн хувьцаа/ нэгж эрх | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Өрийн бичиг** | 4,866 | 4,687 | 4,326 | 4,427 | 4,811 | 5,157 |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад) | 589 | 608 | 596 | 633 | 624 | 640 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 589 | 608 | 596 | 633 | 624 | 640 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 3,549 | 3,340 | 2,996 | 3,067 | 2,946 | 2,970 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 3,549 | 3,340 | 2,996 | 3,067 | 2,946 | 2,970 |
| Бусад салбарууд | 728 | 738 | 733 | 726 | 1,241 | 1,547 |
| Богино хугацаат | 2 | 2 | 2 | 2 | 2 | 2 |
| Урт хугацаат | 726 | 736 | 731 | 724 | 1,239 | 1,545 |
| Бусад санхүүгийн байгууллага | 266 | 284 | 272 | 274 | 787 | 1,102 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 266 | 284 | 272 | 274 | 787 | 1,102 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 460 | 452 | 459 | 451 | 451 | 443 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 460 | 452 | 459 | 451 | 451 | 443 |
| **Санхүүгийн үүсмэл хэрэглүүд (нөөцөөс бусад) ба ажилчдын хувьцааны опцион** | **-0** | **6** | **25** | **1** | **1** | **0** |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад) | -0 | 6 | 25 | 1 | 1 | 0 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Санхүүгийн үүсмэл хэрэглүүд (нөөцөөс бусад) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Бусад хөрөнгө оруулалт** | **14,628** | **14,983** | **14,875** | **14,604** | **14,675** | **14,956** |
| **Бусад хөрөнгө** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** |
| **Бэлэн мөнгө ба харилцах** | **2,245** | **2,365** | **2,210** | **2,101** | **2,123** | **2,199** |
| Төв банк | 1,837 | 1,913 | 1,811 | 1,744 | 1,745 | 1,786 |
| Богино хугацаат | 1,837 | 1,913 | 1,811 | 1,744 | 1,745 | 1,786 |
| Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад) | 314 | 330 | 297 | 317 | 327 | 402 |
| Богино хугацаат | 314 | 330 | 297 | 317 | 327 | 402 |
| Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| үүнээс: Банк хоорондын позиц | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 95 | 122 | 102 | 40 | 51 | 11 |
| **Зээл** | **12,102** | **12,345** | **12,392** | **12,261** | **12,265** | **12,389** |
| Төв банк | 188 | 224 | 253 | 252 | 286 | 287 |
| ОУВС-гаас авсан зээл (нөөцөөс бусад) | 188 | 224 | 253 | 252 | 286 | 287 |
| Бусад богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| ОУВС-гаас авсан зээл (нөөцөөс бусад) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 3,772 | 3,902 | 3,933 | 3,981 | 4,238 | 4,293 |
| ОУВС-гаас авсан зээл (нөөцөөс бусад) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад урт хугацаат | 3,772 | 3,902 | 3,933 | 3,981 | 4,238 | 4,293 |
| Бусад салбарууд | 6,850 | 6,811 | 6,787 | 6,668 | 6,462 | 6,458 |
| Богино хугацаат | 292 | 274 | 277 | 259 | 275 | 269 |
| Урт хугацаат | 6,558 | 6,536 | 6,510 | 6,409 | 6,187 | 6,189 |
| Бусад санхүүгийн байгууллага | 529 | 517 | 468 | 417 | 292 | 300 |
| Богино хугацаат | 41 | 42 | 43 | 43 | 44 | 47 |
| Урт хугацаат | 487 | 475 | 426 | 374 | 248 | 252 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 6,322 | 6,294 | 6,319 | 6,251 | 6,170 | 6,158 |
| Богино хугацаат | 251 | 232 | 234 | 216 | 231 | 221 |
| Урт хугацаат | 6,071 | 6,062 | 6,085 | 6,035 | 5,939 | 5,937 |
| **Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем (F60)** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** |
| **Худалдааны зээл ба урьдчилгаа** | **280** | **274** | **273** | **242** | **288** | **368** |
| **Бусад дансны авлага/өглөг** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** |

*Эх сурвалж:* Монголбанк

## ХАВСРАЛТ 3. МОНГОЛ УЛСЫН НИЙТ ГАДААД ӨР ( мянган ам.доллар)

| Үзүүлэлт | 12/30/2016 | 12/31/2017 | 3/31/2018 | 6/30/2018 | 9/30/2018 | 12/31/2018 | 3/31/2019 |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Засгийн газар** | **4,868,606** | **7,320,975** | **7,242,453** | **6,929,304** | **7,048,571** | **7,184,193** | **7,262,273** |
| **Богино хугацаат** | - | - | - | - | - | - | - |
| Харилцах, хадгаламж 5/ | - | - | - | - | - | - | - |
| Өрийн бичиг 4/ | - | - | - | - | - | - | - |
| Зээл | - | - | - | - | - | - | - |
| Худалдааны зээл болон урьдчилгаа | - | - | - | - | - | - | - |
| Бусад өглөг 6/ | - | - | - | - | - | - | - |
| **Урт хугацаат** | 4,868,606 | 7,320,975 | 7,242,453 | 6,929,304 | 7,048,571 | 7,184,193 | 7,262,273 |
| Зээлжих тусгай эрх ЗТЭ-ийн хуваарилалт 7/ | - | - | - | - | - | - | - |
| Харилцах, хадгаламж 5/ | - | - | - | - | - | - | - |
| Өрийн бичиг 4/ | 2,063,528 | 3,548,542 | 3,340,397 | 2,995,995 | 3,067,325 | 2,946,032 | 2,969,549 |
| Зээл | 2,805,078 | 3,772,434 | 3,902,056 | 3,933,308 | 3,981,246 | 4,238,161 | 4,292,724 |
| Худалдааны зээл болон урьдчилгаа | - | - | - | - | - | - | - |
| Бусад өглөг 6/ | - | - | - | - | - | - | - |
| **Төвбанк** | **1,790,751** | **2,025,079** | **2,136,576** | **2,064,703** | **1,995,912** | **2,030,222** | **2,072,409** |
| **Богино хугацаат** | 1,725,434 | 1,837,133 | 1,912,712 | 1,811,484 | 1,743,626 | 1,744,562 | 1,785,788 |
| Харилцах, хадгаламж 5/ | 1,725,434 | 1,837,133 | 1,912,712 | 1,811,484 | 1,743,626 | 1,744,562 | 1,785,788 |
| Өрийн бичиг 4/ | - | - | - | - | - | - | - |
| Зээл | - | - | - | - | - | - | - |
| Худалдааны зээл болон урьдчилгаа | - | - | - | - | - | - | - |
| Бусад өглөг 6/ | - | - | - | - | - | - | - |
| **Урт хугацаат** | 65,317 | 187,946 | 223,864 | 253,218 | 252,286 | 285,660 | 286,621 |
| Зээлжих тусгай эрх ЗТЭ-ийн хуваарилалт 7/ | 65,317 | 187,946 | 223,864 | 253,218 | 252,286 | 285,660 | 286,621 |
| Харилцах, хадгаламж 5/ | - | - | - | - | - | - | - |
| Өрийн бичиг 4/ | - | - | - | - | - | - | - |
| Зээл | - | - | - | - | - | - | - |
| Худалдааны зээл болон урьдчилгаа | - | - | - | - | - | - | - |
| Бусад өглөг 6/ | - | - | - | - | - | - | - |
| **Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)** | **2,417,380** | **2,194,264** | **2,346,852** | **2,310,780** | **2,309,291** | **2,230,371** | **2,393,402** |
| **Богино хугацаат** | 469,093 | 659,008 | 769,008 | 776,745 | 776,901 | 764,047 | 780,225 |
| Харилцах, хадгаламж 5/ | - | 313,669 | 330,056 | 296,720 | 316,964 | 326,765 | 401,848 |
| Өрийн бичиг 4/ | - | - | - | - | - | - | - |
| Зээл | 469,093 | 345,339 | 438,952 | 480,025 | 459,937 | 437,283 | 378,378 |
| Худалдааны зээл болон урьдчилгаа | - | - | - | - | - | - | - |
| Бусад өглөг 6/ | - | - | - | - | - | - | - |
| **Урт хугацаат** | 1,948,288 | 1,535,256 | 1,577,844 | 1,534,035 | 1,532,389 | 1,466,323 | 1,613,176 |
| Харилцах, хадгаламж 5/ | 239,612 | - | - | - | - | - | - |
| Өрийн бичиг 4/ | 611,048 | 589,222 | 608,231 | 596,325 | 632,753 | 624,396 | 640,020 |
| Зээл | 1,097,628 | 946,034 | 969,613 | 937,710 | 899,636 | 841,927 | 973,156 |
| Худалдааны зээл болон урьдчилгаа | - | - | - | - | - | - | - |
| Бусад өглөг 6/ | - | - | - | - | - | - | - |
| **Бусад салбарууд** | **8,121,485** | **7,955,844** | **7,944,407** | **7,895,491** | **7,676,427** | **8,041,874** | **8,384,555** |
| **Богино хугацаат** | 394,395 | 666,472 | 664,933 | 647,164 | 535,544 | 609,018 | 629,607 |
| Харилцах, хадгаламж 5/ | - | 94,606 | 121,945 | 101,945 | 40,009 | 51,278 | 11,200 |
| Өрийн бичиг 4/ | 2,120 | 2,120 | 2,120 | 2,120 | 2,120 | 2,120 | 2,120 |
| Зээл | 217,529 | 292,414 | 274,451 | 277,191 | 258,888 | 274,704 | 268,815 |
| Худалдааны зээл болон урьдчилгаа | 174,746 | 277,332 | 266,418 | 265,909 | 234,527 | 280,915 | 347,473 |
| Бусад өглөг 6/ | - | - | - | - | - | - | - |
| **Урт хугацаат** | 7,727,090 | 7,289,372 | 7,279,474 | 7,248,327 | 7,140,883 | 7,432,856 | 7,754,948 |
| Харилцах, хадгаламж 5/ | - | - | - | - | - | - | - |
| Өрийн бичиг 4/ | 883,672 | 726,032 | 736,129 | 731,154 | 724,309 | 1,238,669 | 1,545,345 |
| Зээл | 6,801,973 | 6,560,413 | 6,536,227 | 6,510,054 | 6,409,456 | 6,187,069 | 6,189,375 |
| Худалдааны зээл болон урьдчилгаа | 41,445 | 2,927 | 7,118 | 7,118 | 7,118 | 7,118 | 20,228 |
| Бусад өглөг 6/ | - | - | - | - | - | - | - |
| **Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын зээллэг** | **7,426,277** | **7,996,494** | **8,235,177** | **8,460,697** | **8,871,427** | **9,228,228** | **9,409,118** |
| Шууд хөрөнгө оруулагчид өгөх өглөг | 7,426,277 | 7,996,494 | 8,235,177 | 8,460,697 | 8,871,427 | 9,228,228 | 9,409,118 |
| Шууд хөрөнгө оруулагчийн өгөх өглөг | - | - | - | - | - | - | - |
| Хамааралтай компани хоорондын өглөг | - | - | - | - | - | - | - |
| **Нийт гадаад өр** | **24,624,500** | **27,492,657** | **27,905,465** | **27,660,975** | **27,901,628** | **28,714,887** | **29,521,757** |

*Эх сурвалж:* Монголбанк